

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН-2022:

САЛБАР ХУРАЛДААН-1

**ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДИЙН САЛБАРЫН ТУЛГАМДАЖ БҮЙ
АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

**Модератор: Ж.Нарангэрэл, ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний
газрын дарга**

ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛ

1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр баримталж буй бодлого, чиглэл-Г.Навчаа, ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamж үйлчилгээний газрын, Анхан лавлагaa шатлалын тусlamжийн хэлтсийн дарга
2. Эх, хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал- Ш.Алтантуяа, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал
3. Эх, хүүхдийн тусlamж үйлчилгээнд олон нийтийн оролцоо-Г.Соёлгэрэл, НҮБ-ын Хүүхдийн сангийн эрүүл мэндийн зөвлөх нар тус тус илтгэл хэлэлцүүллээ.

САЛБАР ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИД

- Эрүүл мэндийн яам
- Харьяа төвүүд
- Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Засаг даргын тамгын газар
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
- ДЭМБ, Азийн хөгжлийн банк, Глобал сан зэрэг нийт 50 гаруй байгууллагын 100 гаруй удирдах албан тушаалтан 10 бүлэгт хуваагдаж, хэлэлцүүлгийг бүлгээр ажиллаж явууллаа.

Хуралдаанд оролцогчдоос дараах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

ЭРХЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

1. Эх, хүүхдийн тухай хуулийг батлуулах;
2. Хүүхэд хамгааллын чиглэлийн байгууллагуудтай хамтран ажиллах, журмыг шинэчлэх;
3. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусlamжийн заавар, журмыг шинэчлэн батлах;
4. Ураг, нярайн эрт илрүүлгийн заавруудыг батлах, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх;
5. Эх, хүүхдийн чиглэлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хүний нөөцийн асуудлыг төрөөс бодлогоор дэмжих;
6. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх үзлэгийг чанаржуулах хүрээнд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах зэрэг саналуудыг хэлэлцлээ.

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Жирэмсний хяналтын нэгдсэн тогтолцоотой болох (Хөдөлгөөнт хүн ам их тул жирэмсний хяналтыг чанар, хүртээмжтэй болгох, эрсдэлтэй жирэмсний хяналтыг сайжруулах);
2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн товтолтой болох;
3. Эрт илрүүлгийн тогтолцоо бий болгох (Ураг үеийн төрөлхийн гажгийн илрүүлэг, нярайн эрт илрүүлэг- зүрх, түнх, сонсгол, нүдний улаан рефлекс, бодисын солилцоо, дутуу нярайн ретинопатия);
4. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусlamжийг чанаржуулах, перинаталогийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;
5. Төрөх өрөөнд эх, нярайд үзүүлэх тусlamж үйлчилгээг чанаржуулах

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

1. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлдэг эмч, мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын нэгдсэн хөтөлбөртэй болох;
2. Хүүхэд, эх барихын эмч нарын тасралтгүй сургалтыг зохион байгуулах, аймаг, дүүрэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах;
3. Эх нярайд үзүүлэх яаралтай тусlamжийн бэлэн байдлыг хангуулах хүрээнд мэргэжил арга зүйгээр хангаж дэмжлэгт хяналт хийх (ЭХЭМҮТ);
4. Төрөлтийн тоо цөөн сумын эрүүл мэндийн төв болон алслагдсан орон нутагт мэргэшсэн эх баригч, багийн эмчийг бэлтгэх, орон тоогоор ажиллуулах;
5. Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан хөтөлбөрийг дэмжиж ажиллуулах;

ИРГЭДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

1. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлд НЭМҮТ , анхан болон лавлагaa шатлалууд хамтран ажиллах
2. Өсвөр үе (нөхөн үржихүйн эрхтний эрүүл ахуй, өсөлт хөгжилт гэх мэт)
3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх, жирэмслэхэд бэлтгэх;
4. Жирэмсэн эмэгтэйн орчныг дэмжих (гэр бүл, амьдрах орчин, хамт олон...);
5. Жирэмсний аюултай ерөнхий шинж, нярай ба бага насны хүүхдэд илрэх аюултай ерөнхий шинжийг таних, цаг алдалгүй эмнэлэгт хандах мэдлэгтэй болгох зорилгоор, иргэдэд зориулсан гарын авлага, контент хийж түгээх;
6. Олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн сургалтыг үргэлжлүүлэн дэмжлэгт хяналтаар ханган ажиллах;

САЛБАР ДУНДЫИН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлд бүх шатны боловсролын байгууллагатай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах;
2. Гэр бүл төлөвлөлтийн чиглэлд төрийн бус байгууллага, орон нутгийн удирдлагын дэмжлэг авч, сургалт зохион байгуулж хамтран ажиллах;
3. Цалинтай ээж хөтөлбөрийн мөнгийг нэмэх зэрэг зөвлөмжүүдийг хэлэлцүүлгийн явцад гаргаж ажиллалаа.